

Кейс «Хувцасны дэлгүүр: 1С нь бэлэн хувцас болон гутлын дэлгүүрүүдэд зориулсан шилдэг шийдэл юм»

Төслийн захиалагч: SRT LLC

Харилцагчийн танилцуулга:

Дэлхийд алдартай Zara, Soobe, Oysho, Ipekyol, Machka, MassimoDutti, Stradivarius, Oltre зэрэг брэндийн 20 000 гаруй хувцас, гутал, гоёл чимэглэлийн зүйлсийг худалдан борлуулдаг сүлжээ дэлгүүр бөгөөд павильоны нийт талбай нь 150 гаруй квадрат метр юм.

Өдөрт нийт 10 000 гаруй худалдан авагчид үйлчлүүлдэг орчин үеийн худалдааны төвүүдэд өөрийн аутлет дэлгүүрүүдийг нээн ажиллуулдаг.



Төслийн хэрэгжилтийн удирдамж:

Жижиглэнгийн худалдаа болон агуулахыг цогцоор нь автоматжуулахын тулд Монголд зориулан хөгжүүлсэн 1С: Enterprise програм хангамжийн цогц шийдлийг сонгосон бөгөөд энэхүү шийдэл нь өөрийн бизнесийн бүхий л талбаруудын үйл ажиллагааг үр өгөөжтэй эрхлэн явуулах, худалдан авагч нартай бөөний болон жижиглэн худалдааны борлуулалт хийх, лоялти болон хөнгөлөлт урамшууллын уян хатан хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, бараа материалын хэмжээ, өнгө болон бусад мэдээллийг оруулах эсвэл ачаалж оруулах боломжийг олгосон юм. Агуулахын програмыг хамт ашигласнаар бараа хадгалах, мөн борлуулах газруудын барааны бодит үлдэгдэл, бэлэн байдлыг харах боломжтой болсон бөгөөд дэлгүүрийн кассын пос машинүүд нь төв оффис болон бие биенээсээ үл хамааран бие даан ажилласанаар сүлжээ холбооны тасалдал, тоног төхөөрөмжийн эвдрэл гэмтэл, програм хангамжийн гэмтэл, саатал зэргийн улмаас дэлгүүрүүдийн

үйл ажиллагаанд хүндрэл учруулахгүй хэвийн үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах, мөн татвар, нягтлан бодох бүртгэл болон удирдлагын тайлангуудыг Монгол улсын хууль тогтоомжийн дагуу бүрдүүлэн гаргах боломжтой болсон юм.


Ашиглаж байгаа дараах програмын бүтээгдэхүүнүүд нь:

- 1С: Нягтлан бодох бүртгэл 8 – Нягтлан бодох болон татварын бүртгэлийг автоматжуулж, тайлан балансыг зохих маягтуудын дагуу бэлтгэж гаргах.
- 1С: Худалдааны удирдлага 8 – Агуулах, Худалдааны үйл ажиллагааг автоматжуулж, Удирдлагын тайлан гаргах, CRM, өр төлбөрийг тооцож, хянах, баар код ашиглах, борлуулалт болон худалдан авалтын судалгаа шинжилгээ хийх, ашигтай болон алдагдалтай бизнесийн чиглэлийг тодорхойлох, байгууллагын удирдлага болон нягтлан бодогч нарт зориулсан тайлангийн уян хатан механизм зэргийг хэрэгжүүлэх.
- 1С: Жижиглэнгийн худалдаа 8 – Жижиглэнгийн борлуулалтыг автоматжуулж, лоялти болон хөнгөлөлт урамшуулал, барааны буцаалт хийх, мөн хуваарилагдсан өгөгдлийн сан ашиглах схемийг хэрэгжүүлэх боломжийг олгоно.

1С: Enterprise систем нь Худалдааны тоног төхөөрөмжийн тусламжтай барааны тооллого хийх, орлогодох, баар кодоор бараа сонгох, агуулах болон худалдааны танхимын ажил үйлчилгээг тодорхойлж зохион байгуулах, заасан форматын дагуу шошго, үнэ заагчийг хэвлэх, түгээлтийн дотоодын баримт бичгүүдийг үйлдэх зэрэг компанийн олон тооны үйл ажиллагааг хөнгөвчилсөн юм.

Системийг нэвтрүүлэх явцад худалдааны дараах тоног төхөөрөмжийг сонгон тохиргоо хийсэн:

- Кассын пос SkyPOS
- USB-ээр холбох суурин БК Сканерууд Speedscan
- Мобайл Bluetooth, БК сканерууд Speedscan
- Чек хэвлэх принтер
- Шошго хэвлэх принтер Sewoo LK-P41, Bluetooth-ийг дэмжинэ
- Эквайрингийн терминал





Уг шийдлийг өөрийн үйл ажиллагаандаа нэвтрүүлснээр дараах давуу талууд бий болсон:

- Бараа хүлээн авах, борлуулах процесс ил тод болж илүү зохион байгуулалттай болсон
- Барааны бүртгэл болон тооллогыг илүү хурдан хийдэг болсон
- eBarimt-тай холбоотой зохих хуулийн шаардлагыг бүрэн хангадаг болсон
- Худалдан авагчдад зориулсан хөнгөлөлт урамшуулал болон лоялти хөтөлбөр, мөн бусад олон маркетингийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх уян хатан хэрэгслүүдтэй болсон
- Агуулахын үйл ажиллагаа болон барааны нөөцийн бүртгэл илүү зохион байгуулалттай болж, цэгцэрсэн
- 1С: Enterprise програмын бүтээгдэхүүнийг нэмж хөгжүүлэх, дэмжих үйлчилгээ авах нийт зардлыг урьдчилан төлөвлөх боломжтой болсон
- Борлуулалт, агуулахын барааны нөөцийн эргэц, барааны өртгийн тооцоонд судалгаа шинжилгээ хийхэд зориулсан дэлгэрэнгүй тайлан мэдээ гаргадаг болсон
- Дэлгүүрүүдийн сүлжээ, тоног төхөөрөмж болон програм хангамжтай холбоотой сул зогсолт багасаж буурсан юм.

Хөгжлийн төлөвлөгөө:

Ойрын ирээдүйд дараах боломжийг олгох банкны нэгдсэн DataBank терминалыг ашиглахаар төлөвлөж байна:

- чекийн үнийн дүнг терминал руу автоматаар дамжуулж, кассын ажилтан үйлчлүүлэгчийг түргэн шуурхай үйлчилнэ
- янз бүрийн өөр өөр банкны терминалын тоон багасна

- кассын ажилтны ажлын байртай холбоотой зохих хэмнэлт гарна
- 1С:Жижиглэнгийн худалдаа програмаас үнийн дүнг автоматаар терминал руу дамжуулах явцад алдаа гарахгүй болно.

Энэ тохиолдолд татварын буцаалт авч, сугалаанд оролцох худалдан авалтын чекийг eBarimt системийн худалдан авагчийн хувийн буланд автоматаар бүртгэнэ.

Мөн 1С: Тооллого мобайл хэрэглэгчийг үүсгэж нэвтрүүлэхээр төлөвлөж байна. Энэ нь CipherLAB мэдээлэл цуглуулах терминалын тусламжтай агуулахын барааны тооллогыг 2 дахин хурдан хийх боломжийг олгоно.

Захиалагчийн сэтгэгдэл:



Andrey Gudkov, Executive Director, SRT Mongolia

Манай компани нь хэд хэдэн шалтгааны улмаас худалдааны үйл ажиллагааг автоматжуулах 1С:Enterprise програмын бүтээгдэхүүнийг сонгосон юм. Нэгдүгээрт, энэ нь манай үйл ажиллагаатай холбоотой олон тооны асуудлуудыг шийдвэрлэх чадвартай орчин үеийн цогц шийдэл юм. Агуулахын бүртгэлийг хөтлөх, барааны эргэлтийн ил тод байдлыг хангах, компанийн мөнгөн урсгалыг удирдах, програмын үйл ажиллагааны янз бүрийн үзүүлэлтээр гаргаж болох тайлангууд нь бизнесийн гүйцэтгэлийн гол шалгуур үзүүлэлтүүдийг хянах боломжийг олгодог юм. Мөн систем дээр Маркетингийн үйл ажиллагаа, хөнгөлөлт, урамшуулал, үнэнч худалдан авагчдын лоялти карт зэргийг удирдах уян хатан хэрэгслүүдийг хэрэгжүүлсэн байдаг. Санхүүгийн тайлан мэдээ гаргахад 1С:Нягтлан бодох бүртгэл програмыг ашигладаг бөгөөд тайлан мэдээг цаг хугацаанд нь түргэн шуурхай гар ажиллагаагүй автоматаар гаргах боломжийг олгох мэдээлэл солилцоо системүүдийн хооронд явагдана. 1С програмын бүтээгдэхүүнийг хэрэгжүүлж, цаашид дэмжих үйлчилгээ үзүүлэх хамтрагчаар бид ВанСиФорус компанийг сонгосон бөгөөд тэд ч өөрсдийгөө найдвартай, хариуцлагатай түнш гэдгээ харуулахын зэрэгцээ програмын бүтээгдэхүүнүүдийг суулгаж, тохируулах, манай ажилтнуудыг сургаж дадлагажуулах ажлыг үр дүнтэй зохион байгуулсны улмаас бид өөрсдийн дэлгүүрийг цаг хугацаанд нь нээн ажиллуулсан юм. Манай компани цаашид ч өргөжин хөгжих тул бидний хоорондын хамтын ажиллагаагаа үргэлжлүүлнэ гэдэгт би итгэлтэй байна.